

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Боловсролын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/46/НА-СТА-ТШЗ

Цахим www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	хуудас:	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: С.Нацагдорж Утас: 260512 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Оюунтөгөлдөр Утас: 261729 Цахим хаяг: oyuntuguldurg@audit.gov.mn Аудитор: Д.Батчимэг Утас: 261729 Цахим хаяг: batchimegda@audit.gov.mn
---	---------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал.....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	21
4.5.1 Завсрын аудитын талаар.....	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	22
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	23
5.2 Албан шаардлага.....	23
5.3 Зөвлөмж	26
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	28

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БЕГ	Боловсролын ерөнхий газар
БНСУ	Бүгд найрамдах солонгос улс
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
УСНББОУС	Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/353

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсролын яамны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Улсын Их Хурлаас 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдөр “Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийг соёрхон баталсан. Тус хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл-2” төслийн нэмэлт санхүүжилтэд 150.0 сая ам.доллар буюу 533,499,000.0 мянган төгрөг батлагдсанаас 2026 онд 32 сургууль, 9 цэцэрлэг барихаар төлөвлөсөн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Боловсролын яамны санхүүгийн тайланд өөрөө ашигладаггүй, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан 5,940,000.0 мянган төгрөгийн өртөгтэй оюутны дотуур байрны барилга бүртгэлтэй байна. Тайлант онд тус барилгад 321,750.0 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцож, бүртгэсэн байна.

Тус яамны санхүүгийн тайланд өмчлөл, эзэмшил, ашиглалтын зохицуулалт тодорхойгүй хөрөнгийг бүртгэснээр элэгдлийн зардал тооцож, санхүүгийн үр дүн бодитой, үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх эрсдэлтэй байна.

Бусад асуудал

Засгийн газрын 2024 оны 42 дугаар тогтоолоор яамны орон тооны хязгаарыг 110 байхаар баталснаас Засгийн газрын хуралдаанаас өгсөн үүргийн дагуу харьяа байгууллагын чиг үүргийн давхардлыг арилгах шинжилгээ хийж, Боловсролын ерөнхий газрын 10 орон тоог тус яаманд шилжүүлэхээр шийдвэрлэж, Засгийн газрын 2025 оны 53 дугаар тогтоолоор яамны орон тооны хязгаарыг 120 болгон нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлын хэсгийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	261,665,182.76	376,204,228.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	470,000.00	-
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	470,000.00	-
31210	Төгрөг	470,000.00	-
31211	Төрийн сангийн харилцах	470,000.00	-
33	АВЛАГА	89,008,534.76	79,270,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	89,008,534.76	79,270,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	172,186,648.00	296,934,228.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	81,196,670.00	220,199,130.00
35400	Хангамжийн материал	90,989,978.00	76,735,098.00
35410	Бичиг хэргийн материал	26,336,460.00	25,797,680.00
35420	Аж ахуйн материал	41,531,218.00	41,948,118.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,862,000.00	1,862,000.00
35440	Түлш, шатах тослох материал	14,485,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	6,775,300.00	7,127,300.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,869,137,283.81	7,535,435,619.85
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,869,137,283.81	7,535,435,619.85
39200	Биет хөрөнгө	7,851,314,745.45	7,526,509,211.85
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,940,000,000.00	5,940,000,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(321,750,000.00)	(420,750,000.00)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	153,744,283.33	228,744,283.33
39204	Хуримтлагдсан элэгдэл	(86,494,629.61)	(131,365,104.57)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,742,243,905.23	4,117,752,060.23
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,748,735,191.73)	(2,433,090,572.06)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	574,129,778.52	671,041,843.52
39208	Хуримтлагдсан элэгдэл	(401,823,400.29)	(445,823,298.60)
39300	Биет бус хөрөнгө	17,822,538.36	8,926,408.00
39301	Програм хангамж	3,553,709,507.97	3,553,709,507.97
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,535,886,969.61)	(3,544,783,099.97)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	8,130,802,466.57	7,911,639,847.85
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	225,051,532.25
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	225,051,532.25
41300	Өглөг	-	225,051,532.25
41360	Бусад өглөг	-	225,051,532.25
41361	Байгууллагад төлөх өглөг	-	225,051,532.25
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,130,802,466.57	7,686,588,315.60
51	Засгийн газрын хувь оролцоо	8,130,802,466.57	7,686,588,315.60
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,135,349,477.27	1,135,349,477.27
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	1,135,349,477.27	1,135,349,477.27
51200	Хуримтлагдсан үр дүн	6,995,452,989.30	6,551,238,838.33
51210	Өмнөх үеийн үр дүн	7,242,248,213.64	7,046,162,769.30
51220	Тайлант үеийн үр дүн	(246,795,224.34)	(494,923,930.97)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	8,130,802,466.57	7,911,639,847.85

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	12,067,258,584.80	7,321,285,282.94
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	908,766,448.86	7,321,285,282.94
120	Нийтлэг татварын бус орлого	908,766,448.86	613,910,064.95
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,102,800.00	375,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,102,800.00	375,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	907,663,648.86	513,297,054.95
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	100,238,010.00
122	Тусламжийн орлого	-	6,707,375,217.99
1221	Хандив тусламж /дотоод/	-	6,707,375,217.99
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	6,373,107,300.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	6,373,107,300.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	334,267,917.99
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	334,267,917.99
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	11,158,492,135.94	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8,794,004,846.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	8,794,004,846.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,364,487,289.94	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	591,575,258.94	-
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,772,912,031.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	12,313,933,809.14	7,814,054,381.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,313,933,809.14	7,814,054,381.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,934,977,663.14	7,564,021,378.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,560,553,000.00	4,848,590,172.21
210101	Үндсэн цалин	2,524,909,516.00	2,526,164,504.21
210102	Нэмэгдэл	1,073,316,900.00	1,343,171,700.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	565,805,084.00	742,138,529.00
210104	Урамшуулал	396,521,500.00	232,542,639.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	4,572,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	565,151,700.00	654,374,800.00
210201	Тэтгэврийн даатгалын зардал	369,562,900.00	466,424,800.00
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	48,897,200.00	46,987,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	24,448,600.00	23,493,800.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	24,448,600.00	23,493,800.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	97,794,400.00	93,974,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,079,480,564.01	103,345,914.06
210401	Бичиг хэрэг	72,955,280.00	30,580,780.00
210402	Тээвэр, шатахуун	-	14,485,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	33,186,613.01	52,831,734.06
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,906,640.00	5,448,400.00
210409	Бараа материал шилжүүлсний зардал	1,966,432,031.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,521,000.00	49,015,295.00
210604	Урсгал засвар	43,521,000.00	49,015,295.00
2107	Томиллолт, зочны зардал	-	151,735,892.00
210701	Гадаад албан томиллолт	-	4,282,462.00

Боловсролын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд
хийсэн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	-	147,453,430.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,793,070,231.03	760,140,110.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,786,868,131.03	751,690,210.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,202,100.00	8,449,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,893,201,168.10	996,819,195.55
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,672,786,766.99	110,325,131.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	34,130,178.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,220,414,401.11	852,363,886.55
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	378,956,146.00	250,033,002.73
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	133,214,654.73
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	133,214,654.73
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	133,214,654.73
2131121	Санхүүжилтийн үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	82,504,874.73
2131122	Төсвийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	50,709,780.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	372,853,346.00	116,818,348.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	255,345,346.00	97,612,348.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	117,508,000.00	19,206,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,102,800.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,102,800.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(246,675,224.34)	(492,769,098.61)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	120,000.00	2,154,832.36
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	120,000.00	2,154,832.36
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(120,000.00)	(2,154,832.36)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	(246,795,224.34)	(494,923,930.97)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	<u>11,223,310,032.79</u>	<u>6,847,468,532.75</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,102,800.00	6,847,468,532.75
120	Нийтлэг татварын бус орлого	1,102,800.00	51,084,780.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,102,800.00	51,084,780.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,102,800.00	51,084,780.00
122	Тусламжийн орлого	-	6,796,383,752.75
1221	Хандив тусламж /дотоод/	-	6,796,383,752.75
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	6,373,107,300.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	6,373,107,300.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	423,276,452.75
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	423,276,452.75
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	11,222,207,232.79	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8,794,004,846.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	8,794,004,846.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,428,202,387.79	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	655,290,355.79	-
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,772,912,031.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	<u>11,287,590,032.79</u>	<u>6,847,938,532.75</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,287,590,032.79	6,847,938,532.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,819,625,352.03	6,518,635,530.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,560,553,000.00	4,848,590,172.21
210101	Үндсэн цалин	2,524,909,516.00	2,526,164,504.21
210102	Нэмэгдэл	1,073,316,900.00	1,343,171,700.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	565,805,084.00	742,138,529.00
210104	Урамшуулал	396,521,500.00	232,542,639.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	4,572,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	565,151,700.00	654,374,800.00
210201	Тэтгэврийн даатгалын зардал	369,562,900.00	466,424,800.00
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	48,897,200.00	46,987,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	24,448,600.00	23,493,800.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	24,448,600.00	23,493,800.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	97,794,400.00	93,974,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	54,088,000.00	80,452,502.17
210401	Бичиг хэрэг	17,955,000.00	16,362,050.00
210402	Тээвэр, шатахуун	-	2,592,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	26,989,270.00	51,412,882.17
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,143,730.00	10,085,070.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	52,770,000.00	20,000,000.00
210604	Урсгал засвар	52,770,000.00	20,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	145,090,930.00
210702	Дотоод албан томилолт	-	145,090,930.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,126,419,121.03	607,829,227.75

Боловсролын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд
хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,117,458,021.03	595,661,552.75
210803	Даатгалын үйлчилгээ	1,616,200.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	343,400.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	40,400.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,961,100.00	12,167,675.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,460,643,531.00	162,297,897.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,460,643,531.00	95,040,797.89
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	67,257,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	467,964,680.76	329,303,002.73
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	212,484,654.73
21311	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	212,484,654.73
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	212,484,654.73
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	82,504,874.73
2131122	Төсвийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	50,709,780.00
2131125	Төсвийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	470,000.00
2131126	Нэмэлт санхүүжилтийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	78,800,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	372,853,346.00	116,818,348.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	255,345,346.00	97,612,348.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	117,508,000.00	19,206,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	95,111,334.76	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,102,800.00	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	89,008,534.76	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(64,280,000.00)	(470,000.00)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	35,250,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	35,250,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	35,250,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	35,250,000.00	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(35,250,000.00)	=
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(99,530,000.00)	(470,000.00)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	100,000,000.00	470,000.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	470,000.00	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,135,349,477.27	-	7,242,248,213.64	8,377,597,690.91
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,135,349,477.27	-	7,242,248,213.64	8,377,597,690.91
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(246,795,224.34)	(246,795,224.34)
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,135,349,477.27	-	6,995,452,989.30	8,130,802,466.57
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	50,709,780.00	50,709,780.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,135,349,477.27	-	7,046,162,769.30	8,181,512,246.57
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(494,923,930.97)	(494,923,930.97)
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,135,349,477.27	-	6,551,238,838.33	7,686,588,315.60

/төгрөгөөр/

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,631,926,100.00	6,290,977,425.27	340,948,174.73	94.8
12	Татварын бус орлого	6,631,926,100.00	6,290,977,425.27	340,948,174.73	94.8
120	Нийтлэг татварын бус орлого	-	375,000.00	(375,000.00)	-
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	375,000.00	(375,000.00)	-
122	Тусламжийн орлого	6,631,926,100.00	6,290,602,425.27	340,948,174.73	94.8
122005	Төсвөөс санхүүжих	6,631,926,100.00	6,290,602,425.27	340,948,174.73	94.8
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,631,926,100.00	6,290,977,425.27	340,948,174.73	94.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,631,926,100.00	6,290,977,425.27	340,948,174.73	94.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,511,129,700.00	6,174,159,077.27	336,970,622.73	94.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,953,067,800.00	4,848,590,172.21	104,477,627.79	97.8
210101	Үндсэн цалин	2,818,993,700.00	2,526,164,504.21	292,829,195.79	89.6
210102	Нэмэгдэл	1,343,171,700.00	1,343,171,700.00		100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	583,786,900.00	742,138,529.00	(158,351,629.00)	127.1
210104	Урамшуулал	202,542,700.00	232,542,639.00	(29,999,939.00)	114.8
210105	Гэрээт ажлын хөлс	4,572,800.00	4,572,800.00		100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	654,374,800.00	654,374,800.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	466,424,800.00	466,424,800.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	46,987,500.00	46,987,500.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	23,493,800.00	23,493,800.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	23,493,800.00	23,493,800.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	93,974,900.00	93,974,900.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	87,316,900.00	80,452,502.17	6,864,397.83	92.1
210401	Бичиг хэрэг	16,992,300.00	16,362,050.00	630,250.00	96.3
210402	Тээвэр, шатахуун	2,592,500.00	2,592,500.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	51,571,500.00	51,412,882.17	158,617.83	99.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,160,600.00	10,085,070.00	6,075,530.00	62.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,200,000.00	20,000,000.00	3,200,000.00	86.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,200,000.00	-	3,200,000.00	-
210604	Урсгал засвар	20,000,000.00	20,000,000.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	145,100,000.00	145,090,930.00	9,070.00	99.9

Боловсролын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд
хийсэн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	145,100,000.00	145,090,930.00	9,070.00	99.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	468,252,300.00	263,352,775.00	204,899,525.00	56.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	448,457,600.00	251,185,100.00	197,272,500.00	56.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	19,794,700.00	12,167,675.00	7,627,025.00	61.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	179,817,900.00	162,297,897.89	17,520,002.11	90.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	95,040,800.00	95,040,797.89	2.11	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	84,777,100.00	67,257,100.00	17,520,000.00	79.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	120,796,400.00	116,818,348.00	3,978,052.00	96.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	120,796,400.00	116,818,348.00	3,978,052.00	96.7
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	97,649,400.00	97,612,348.00	37,052.00	99.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,147,000.00	19,206,000.00	3,941,000.00	82.9
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	470,000.00	(470,000.00)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	95	115	20	121.0
620001	Удирдах ажилтан	19	18	(1)	94.7
620002	Гүйцэтгэх ажилтан	76	97	21	127.6

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	-	423,276,452.75
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	423,276,452.75
122	Тусламжийн орлого	-	423,276,452.75
1221	Хандив тусламж /дотоод/	-	423,276,452.75
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	423,276,452.75
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	423,276,452.75
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	344,476,452.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	344,476,452.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	344,476,452.75
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	344,476,452.75
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	344,476,452.75
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	78,800,000.00
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(78,800,000.00)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт		(78,800,000.00)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Боловсролын яам нь хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичиг, “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030”, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, улсын хөгжлийн төлөвлөгөө, Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний бодлогыг төлөвлөх, хэрэгжилтийг хангах, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, харьяа агентлагийн үйл ажиллагааг шуурхай удирдлагаар хангаж, зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Боловсролын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг Засгийн газрын 2025 оны 7 дугаар тогтоолоор баталсан бөгөөд эрхэм зорилгоо “Боловсролын салбарын үйл ажиллагааг хөгжлийн чиг хандлага, нийгэм, соёлын үнэт зүйл, хэрэгцээнд нийцүүлэх, боловсронгуй болгох, бүх хүний сурч боловсрох эрхийг хангах, тэгш боломжийг бүрдүүлэх, зөв, оновчтой бодлогыг тодорхойлж төрт ёс, түүх, соёл, уламжлал, үнэт зүйлсийг өвлөсөн, ардчилсан, хүмүүнлэг, ёс зүйг дээдлэн сахисан, дэлхийд өрсөлдөхүйц мэдлэг чадвартай, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулдаг, эрүүл, хариуцлагатай, төлөвшсөн иргэнийг бэлтгэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Боловсролын салбарын бодлого төлөвлөх;
- Дээд боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын өрсөлдөх чадвартай, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ур чадварын шаардлагад нийцсэн хүний нөөц бэлтгэх, хөгжүүлэх, түншлэлд суурилсан мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын бодлогыг тодорхойлж, хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах;
- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын бодлого тодорхойлох, хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах;
- Боловсролын салбарын санхүү, хөрөнгө оруулалт, эдийн засгийн нөөцийн төлөвлөлт, удирдлагыг хэрэгжүүлэх, гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлж, хөгжүүлэх;
- Боловсролын стандартын хэрэгжилтийг хангуулах, эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх, салбарын болон яамны үйл ажиллагааны дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээг чанаржуулах, эрсдэлийн удирдлага, зөвлөмжөөр хангах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Боловсролын яам нь Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Хөдөлмөрийн

тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль, тогтоомжуудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5 дах хэсэгт 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт орсон;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон;
- Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаал "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам" шинэчлэн батлагдсан;
- Засгийн газрын 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 215 дугаар тогтоолоор Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээлийг эргэн төлүүлэх журам шинэчлэн батлагдсан;
- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 214 дүгээр тогтоолоор Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам батлагдаж, 2025 оноос даган мөрдөж байна;
- Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 226 дугаар тогтоолоор Төрийн жинхэнэ албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосон;
- Засгийн газрын 2025 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн 158 дугаар тогтоолоор 2026 оныг "боловсролыг дэмжих жил" болгон зарласан;
- Боловсролын сайдын 2025 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн А/465 дугаар тушаалаар Боловсролын цахим мэдээллийн сан бүрдүүлэх, ажиллуулах журам шинэчлэн батлагдсан.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Боловсролын сайд, Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн хүрээнд тус яамны дотоод аудитын нэгж 2025 оны төлөвлөгөөний дагуу 4 байгууллага, арга хэмжээнд төлөвлөгөөт, 10 байгууллагад төлөвлөгөөт бус дотоод аудитыг хийж 15,082,214.3 мянган төгрөгийн зөрчлийг илрүүлснээс 96,454.6 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн актыг тогтоож, 150,616.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 15,035,990.6 мянган төгрөгийн зөрчлийг хуулийн байгууллагад шилжүүлсэн байна. Боловсролын сайдын дэргэдэх Дотоод аудитын хороогоор 4 байгууллагын үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудит, хяналт шалгалтын тайланг хэлэлцүүлж, хорооны тогтоолоор үйл ажиллагааг сайжруулах 36 зөвлөмжийг өгч ажилласан бөгөөд биелэлт 92.5 хувьтай байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Боловсролын яамны 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус яам нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/22 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажилладаг бөгөөд уг баримт бичиг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн боловч, санхүүжилт, дотоод хяналт, үйл ажиллагааны онцлогийг нарийвчлан тусгаагүй, ерөнхий байдлаар боловсруулсан шинээр батлагдан гарч буй стандарт, хууль тогтоомж, заавар, журамтай нийцүүлэн шинэчлэлт өөрчлөлт хийгдээгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Боловсролын яамны 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн, өмнөх оноос 219,162.6 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	470.0	-	(470.0)
Авлага	89,008.5	79,270.0	(9,738.5)
Бараа материал	172,186.7	296,934.2	124,747.6
Үндсэн хөрөнгө	7,869,137.3	7,535,435.6	(333,701.7)
Нийт хөрөнгө	8,130,802.5	7,911,639.8	(219,162.6)
Өр төлбөр	-	225,051.5	225,051.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	8,130,802.5	7,686,588.3	(444,214.2)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	8,130,802.5	7,911,639.8	(219,162.6)

Дээрх хүснэгтээс харахад дараах дансны үлдэгдэлд материаллаг дүнтэй өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Авлага дансны үлдэгдэл 9,738.5 мянган төгрөгөөр буюу 10.9 хувиар буурсан нь төрийн санд төвлөрүүлсэн нэмэлт санхүүжилтийн дансны НҮБ-ын Хүн амын

сантай хамтран хэрэгжүүлж буй арга хэмжээний 78,800.0 мянган төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн;

- Бараа материалын дансны үлдэгдэл 296,934.2 мянган төгрөг болж, 124,747.6 мянган төгрөгөөр өссөн нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад зориулж 132,567.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 108,057.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой.
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 333,701.7 мянган төгрөгөөр буюу 4.2 хувиар буурсан нь 513,297.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэн авч, тайлант хугацаанд 852,363.9 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон нь нөлөөлсөн байна.
- Өр төлбөрийн дансны үлдэгдэл 225,051.5 мянган төгрөг болсон нь нийтлэг үйлчилгээний зардлын 211,570.3 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлын 13,480.7 мянган төгрөгийн санхүүжилт дутуу олгогдсонтой холбоотой.
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 7,686,588.3 мянган төгрөг болж, 444,214.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

Судалгааны үр дүн: Тус яамны биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглаж байгаа 16,250.0 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн 2 программ, яамны үйл ажиллагаа болон албан хаагчдын албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа 465,337.9 мянган төгрөгийн өртөгтэй 2 сервер, 21,780.0 мянган төгрөгийн өртөгтэй дотоод үйл ажиллагаа, албан хэрэг хөтлөлтийн 1 систем байна. Тайлант онд программ хангамж хөгжүүлэхтэй холбоотой зардал гараагүй.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 7,930,498.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 1,298,571.9 мянган төгрөгөөр бууруулж 6,631,926.1 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд:

Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 31,986.2 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 21,316.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, бусад урсгал шилжүүлгийн зардлыг 364,203.6 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 628,205.3 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 220,182.1 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 34,900.0 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 26,800.0 мянган төгрөгөөр, цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 26,041.6 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 51,542.4 мянган төгрөгөөр тус тус бууруулж нийт 6,631,926.1

мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй төлөвлөөгүйгээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 6,631,926.1 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 6,373,107.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлого 51,084.8 мянган төгрөгийг бүрдүүлж, 6,290,977.4 мянган төгрөгийг зарцуулж, 133,214.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,290,977.4 мянган төгрөг буюу 94.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 139,698.1 мянган төгрөгөөр, байр ашиглалтын үйлчилгээний зардлын төсвийг 197,272.5 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардлын төсвийг 3,978.1 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
71808	Боловсрол, ШУ-ны бодлого удирд	-	-	-	-
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	6,062,672.1	5,922,974.0	139,698.1	97.7
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	448,457.6	251,185.1	197,272.5	56.0
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	120,796.4	116,818.3	3,978.1	96.7
Бүгд		6,631,926.1	6,290,977.4	340,948.7	94.9

Судалгааны үр дүн: Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад тус байгууллагаас дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ. Тухайлбал:

- Тайлант онд Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 7 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар 6 газар, 6 хэлтэс, орон тооны хязгаарыг 100 байхаар баталсан ба, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 53 дугаар тогтоолоор тус яамны орон тооны хязгаарыг 120 болгож нэмэлт өөрчлөлт оруулсан байна.
- Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар: Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны А/93 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 4.5.5-д 1 хүнд ногдох хоолны хөнгөлөлтийг өдрийн 30.0 мянган төгрөг, унааны хөнгөлөлтийг 3.0 мянган төгрөгөөр тогтоож тайлант хугацаанд 742,138.5 мянган төгрөгийн хоол, унааны хөнгөлөлт олгосон байна.

- Тайлант хугацаанд тус яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар 3 удаагийн гадаад томилолтын зардалд 4,282.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.
- Тайлант онд хэвлэл, мэдээллийн байгууллагатай байгуулсан гэрээ байхгүй.
- Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал тайлант онд гараагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Нэгдсэн Үндэсний байгууллагын Хүн амын сан, Бүгд Найрамдах Солонгос Улсын ЮНЕСКО, АПСЕИЮ, Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төсөл зэрэг олон улсын байгууллагуудын тусламж, санхүүжилтээр нийт 423,273.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 344,476.5 мянган төгрөгийг зарцуулж, 78,800.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж, татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/21 дүгээр тушаалаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, нийт 183,000.0 мянган төгрөгийн 5 төсөл, арга хэмжээ худалдан авахаар тусгасан байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлаас 94,950.0 мянган төгрөгийн 1 төсөл, арга хэмжээг харьцуулалтын аргаар, 33,000.0 мянган төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг шууд гэрээ байгуулж, 1 төсөл, арга хэмжээ төсөв татагдсан шалтгаанаар худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй, төлөвлөгөөний хэрэгжилт 69.9 хувьтай байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Боловсролын яамны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Боловсролын яам, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Г.Оюунтөгөлдөр, аудитор Д.Батчимэг нар гүйцэтгэж, аудитын үе шатны чанарын хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Боловсролын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 02/346 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 12,314,053.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 123,140.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор сургалт, дадлага бэлтгэлийн зардал, хэвлэл захиалгын төлбөр, зочин төлөөлөгч хүлээн авах, гадаад албан томилолтын зардал зэрэг арга хэмжээг тайлант онд санхүүжүүлээгүй байна.

Боловсролын яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 4 тээврийн хэрэгслээс 3 нь бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар сольсон байна. Үлдсэн 1 тээврийн хэрэгслийг Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2026 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн "Нийслэлийн авто тээврийн хэрэгслийн бүртгэл хяналтын төв"-д "Дэвсгэр өнгө солиулах тухай" 01/573 дугаар албан тоотоор хандсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 1,001,691.0 мянган төгрөгийн зөрчлөөс 935,825.1 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 65,865.9 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хариуцлага тооцуулах албан шаардлага

Илрүүлэлт 1. Боловсролын яам нь шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 36 харилцагчийн 612,435.8 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний худалдан авалт, 13 удаагийн 303,997.1 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ, аудитын мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан зэрэг нийтэд байршуулбал зохих мэдээллийг байршуулаагүй, 17 тайлан мэдээг хугацаа хоцроож, өмнөх оны аудитаар өгсөн шийдвэр бүрэн хэрэгжээгүй, ижил төрлийн зөрчил давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1. "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.1. "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3. "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.4 "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.6 "худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн", 10 дугаар зүйлийн 10.1 "Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1 "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, өмнөх оны аудитаар өгсөн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлээгүй, ижил төрлийн зөрчил

давтан гаргасан тул сахилгын хариуцлага тооцуулах тухай албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль, тогтоомжийн хүрээнд

Албан шаардлага

Илрүүлэлт 1. Тайлант онд хэрэгжүүлсэн 19,391.4 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээ нь ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, бараа, ажил, үйлчилгээ хүлээн авсан комиссын акт, гэрээ дүгнэсэн актгүй, анхан шатны баримтаар нотлогдохгүй байна. Мөн ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг нарийвчлан боловсруулахгүйгээр ерөнхий байдлаар боловсруулсан, гэрээ дүгнэсэн актад гэрээнд заасан шалгуурууд болон актаар хүлээн авсан бараа, ажил, үйлчилгээний хугацаа, нэр төрлийн талаар нарийвчлан тодорхой тусгахгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 “Захиалагч техникийн тодорхойлолтод бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгана”, 12.2 “Техникийн тодорхойлолтод бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд хэрэглэх түүхий эд, материал болон ажлын хүрээнд нийлүүлэх барааны шалгуур үзүүлэлтийг тодорхойлно”, Иргэний хуулийн 195 дугаар зүйлийн 195.2 “Гэрээ байгуулах саналд гэрээний гол нөхцөл буюу түүнийг тодорхойлох журмыг заасан байна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант онд хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээ нь ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, бараа, ажил, үйлчилгээ хүлээн авсан комиссын акт, гэрээ дүгнэсэн актгүй, анхан шатны баримтаар нотлогдохгүй байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж

Илрүүлэлт 1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 65,865.9 мянган төгрөгийн 6 төсөл, арга хэмжээг тусгаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.“Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална”, 46 дугаар зүйлийн 46.1.“Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт,

үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана", Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2."Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна", 2.11.Захиалагч цахим системд нийтэлсэн төлөвлөгөөг мөрдөж ажиллах ба энэ журмын 2.12-т заасан үндэслэлээр батлагдсан төлөвлөгөөнд орсон нэмэлт, өөрчлөлтийг холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын 10 өдөрт багтаан төлөвлөгөөнд өөрчлөлтийг тусган, батална. Хэрэв холбогдох дээд шатны байгууллага байгаа бол төлөвлөгөөний өөрчлөлтийг түүгээр батлуулахаар цахим системээр илгээж, өөрчлөлтийг баталгаажуулна. 2.19. "Захиалагч тухайн жилийн төлөвлөгөөг энэ журамд заасны дагуу цахим системд бүрэн оруулж, батлуулаагүй нь хуульд заасан хариуцлага хүлээх үндэслэл болно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд төсөл, арга хэмжээг бүрэн тусгаж байх цаашид зөрчлийг давтан гаргахгүй ажиллах зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд мэдээллийг бүрэн байршуулаагүй нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Боловсролын яамны 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж завсрын аудит хийж, илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар 603,606.8 мянган төгрөгийн зөрчилд 10 зөвлөмж өгснийг үнэлж, хэрэгжээгүй болон дутуу хэрэгжсэн үндсэн хөрөнгө, бараа материал, зардлын данснуудтай холбоотой асуудал болон шилэн данстай холбоотой зөвлөмжийг энэхүү аудитын тайланд тусгасан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 83,493.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 59,703.4 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж, мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, хариуцлага тооцох 1 албан шаардлага хүргүүлснээс 23,790.0 мянган төгрөгийн 1 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	4	23,790.0	3	-	75.0
Зөвлөмж	1	59,703.4	1	59,703.4	100.0
Нийт дүн	5	83,493.4	4	59,703.4	87.5

Өмнөх онд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн боловч тайлант онд уг зөрчлийг давтан гаргасан тул хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг дараагийн шатны аудитаар анхаарах шаардлагатай гэж үзлээ. Тухайлбал:

- Улсын төсвөөр баригдсан, яам өөрөө ашигладаггүй 5,940,000.0 мянган төгрөгийн өртөгтэй оюутны дотуур байрны барилгыг яамны үндсэн хөрөнгөнд бүртгэн элэгдэл тооцсон;
- Боловсролын мэдээллийн технологийн төв болон төслөөс балансаас балансад шилжиж ирсэн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй ашиглагддаггүй программ хангамжуудыг авч үзэх;
- Тус яам нь Боловсрол, Шинжлэх ухааны сайдын 2021 оны А/22 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна. Тус бодлогын баримт бичигт салбарын үйл ажиллагааны онцлогийг нарийвчлан тусгаагүй, өнөөг хүртэл өөрчлөлт, шинэчлэлт хийгдээгүй байгааг;
- Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын хавсралтад заасан маягтын дагуу бэлтгэхээр зохицуулсан боловч “Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн систем” дэх тайлангийн зарим үзүүлэлт хоорондоо зөрүүтэй байгааг цаашид анхаарах нь зүйтэй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 181,496.3 мянган төгрөгийн 4 алдаа¹ илэрснийг аудитын явцад бүрэн залруулав. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайланд бэлэн бүтээгдэхүүнийг 4,910.6 мянган төгрөгөөр дутуу, хангамжийн материалыг 20,916.9 мянган төгрөгөөр илүү, бичиг хэргийн материалыг 6,404.4 төгрөгөөр илүү тайлагнасан;
- Санхүүгийн байдлын тайланд авто-тээврийн хэрэгслийг 75,000.0 мянган төгрөгөөр дутуу, тээврийн хэрэгслийн хуримтлагдсан элэгдлийг 3,125.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Санхүүгийн байдлын тайланд бусад өглөгийг 14,737.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Санхүүгийн үр дүнгийн тайланд нийт зардлыг 59,401.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж тус тус заасантай нийцэхгүй, УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга 27, 29 дүгээр параграфт заасныг хангахгүй байсныг залруулсан.

Аудитаар нийт 69,598.5 мянган төгрөгийн 9 зөрчил² илэрсэнд, 57,616.9 мянган төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага хүргүүлж, 11,978.6 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 69,598.5 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 123,140.5 мянган төгрөгөөс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1. Анхан шатны баримтын бүрдэл дутуу, зориулалт тодорхойгүй 15,002.3 мянган төгрөгийг зарцуулж, санхүүгийн тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.4 "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хориглоно”, 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэл дутуу, зориулалт тодорхойгүй ажил, гүйлгээг бүртгэлд тусгаж байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2. Тайлант онд анхан шатны баримтын бүрдэл дутуу, нотлох баримтгүйгээр 9,500.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 14.4 "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:", 14.4.1 "аж ахуйн бүх ажил, гүйлгээ" гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэл дутуу, нотлох баримтгүйгээр шатахуун зарцуулж байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 3. Тайлант онд урсгал засвар болон тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээнд ажил гүйцэтгэх гэрээ байгуулаагүй, гүйцэтгэх ажлын төсөв, тооцоогүй нийт 17,886.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.4 "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Урсгал засварын ажлыг гүйцэтгүүлэхдээ гэрээ байгуулаагүй, ажлын төсөв, тооцоогүй, зарцуулж байгаа таслан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 4. Тайлант онд албан томилолтоор ажилласан ажлын тайлан, илтгэх хуудасгүй 7,520.4 мянган төгрөг, тээврийн хэрэгслийн түрээсийн гэрээг дүгнээгүй, жолоочийн тооцооны хуудас хөтлөөгүй 7,253.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар 2-т "Мөнгөн урьдчилгааны тайлан "Мөнгөн урьдчилгааны тайлан нь гадаад, дотоод албан томилолт, хангамжийн урьдчилгаа гэх мэт бүх төрлийн мөнгөн урьдчилгааны гүйцэтгэлийг тайлагнах үндсэн баримт юм. Урьдчилгаа авагчийн гаргасан гүйцэтгэл ба олгосон урьдчилгаа, холбогдох анхан шатны баримттай харьцуулан нягтлан бодогч урьдчилгаа тайланг хянах ба илүү/дутуу зарцуулалтыг урьдчилгааны зориулалт тус бүрээр гаргана", Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/93 дугаар тушаалаар баталсан "Журам шинэчлэн батлах тухай" журмын 3.6.6-д "Албан хаагч нь гадаадад томилолтоор ажилласан эцсийн хугацаанаас хойш ажлын 5 өдөрт багтаан томилолтын тайлан, зардлын гүйцэтгэлийн баримтыг Гадаад харилцаа хамтын ажиллагааны нэгжид, хөдөө орон нутагт ажилласан бол Төрийн захиргааны удирдлагын нэгж болон Санхүү хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжид тус тус хүлээлгэн өгнө" гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан томилолтын зардлын ажлын тайлан, илтгэх хуудасгүй, тээврийн хэрэгслийн түрээсийн гэрээг дүгнээгүй, жолоочийн тооцооны хуудас хөтөлдөггүй зэрэг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 5. Тайлант онд 458.2 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант онд үүссэн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 6. Эд хөрөнгийн тооллогын комиссыг Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн А/132, 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/242 дугаар тушаалаар томилж, тооллого хийсэн боловч тооллогын бүртгэлийг баталгаажуулж, тооцоог бодоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг

баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана.”, 2-т “түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-ээс/”, 72 дугаар зүйлийн 4-т “Тооллогын комисс дараах үүрэгтэй: 4/комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тооллогын бүртгэлийг баталгаажуулж, тооцоог бодоогүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт 1. Зардлын эдийн засгийн ангиллыг зөрчин албан томилолтын зардлаас байрны түрээс, бусад зардалд 11,978.6 мянган төгрөг зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ: 41.2.2 “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, 41.2.4. “төсвийн сар, улирлын хуваарийг баримталж ажиллах”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан Зардлын эдийн засгийн ашиглах заавар” заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулахдаа холбогдох дээд шатны байгууллагаас зөвшөөрөл авч, гүйцэтгэлийг бодитой тайлагнаж байх.

Илрүүлэлт 2. Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг /элэгдэл тооцох/ Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгаагүй, мөн 2019, 2023, 2024 онд ашиглалтад авсан 765,869.0 мянган төгрөгийн 309 ширхэг үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг 0-1 жил ашиглахаар бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйл. “Нягтлан бодох бүртгэлийн стандарт 4.1.3.Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”, 5.1. “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4.үнэн зөв байх; 5.1.6.зохицох”, 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг нэмэлт зардал гаргахгүйгээр НББ-ийн баримт бичигт бүрэн тусгаж, үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг дахин тооцож, хугацааг шинэчлэн тогтоох талаар холбогдох эрх бүхий байгууллагад санал хүргүүлэн, шийдвэрлүүлэх.

Илрүүлэлт 3.

Бараа материалын ангилал, бүртгэлтэй холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Бэлэн бүтээгдэхүүний тодорхойлолт, шинж чанарыг агуулаагүй 25 нэр төрлийн 11,960.6 мянган төгрөгийн 2972 ширхэг бараа материалыг тус ангилалд тайлагнасан;
- Аж ахуйн материал, бусад хангамжийн материалын дансанд ижил төрлийн материалуудыг бүртгэсэн;
- Бараа материалын тайланд Үндсэн хөрөнгийн шинж чанар бүхий 125,525.0 мянган төгрөгийн 20 нэр төрлийн 46 ширхэг хөрөнгийг бүртгэсэн;
- Өмнөх онд ажлаасаа гарсан нярвын нэр дээр 22,877.7 мянган төгрөгийн 64 нэр төрлийн 4,508 ширхэг бараа материалын үлдэгдлийг тайлагнасан байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын ангилал, бүртгэл, тайлагналыг НБББББ болон холбогдох стандартын дагуу зөв ангилалд бүртгэх, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах.

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Санхүүгийн байдлын тайланд бэлэн бүтээгдэхүүнийг 4,910.6 мянган төгрөгөөр дутуу, хангамжийн материалыг 20,916.9 мянган төгрөгөөр илүү, бичиг хэргийн материалыг 6,404.4 төгрөгөөр илүү тайлагнасан байна.	1	32,231.9	-	-	1	32,231.9	1	32,231.9	-	-	-	-
2	Санхүүгийн байдлын тайланд авто-тээврийн хэрэгслийг 75,000.0 мянган төгрөгөөр дутуу, тээврийн хэрэгслийн хуримтлагдсан элэгдлийг 3,125.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.	1	78,125.0	-	-	1	78,125.0	1	78,125.0	-	-	-	-
3	Санхүүгийн байдлын тайланд бусад өглөгийг 14,737.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.	1	14,737.8	-	-	1	14,737.8	1	14,737.8	-	-	-	-
4	Санхүүгийн үр дүнгийн тайланд нийт зардлыг 59,401.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.	1	59,401.6	-	-	1	59,401.6	1	59,401.6	-	-	-	-
	Дүн	4	181,496.3	-	-	4	181,496.3	4	181,496.3	-	-	-	-

Боловсролын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд
хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Анхан шатны баримтын бүрдэл дутуу, зориулалт тодорхойгүй 15,002.3 мянган төгрөгийг зарцуулж, санхүүгийн тайланд тусгасан байна.	1	15,002.3	-	-	1	15,002.3	-	-	-	-	-	-
2	Тайлант онд урсгал засвар болон тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээнд ажил гүйцэтгэх гэрээ байгуулаагүй, гүйцэтгэх ажлын төсөв, тооцоогүй нийт 17,886.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	17,886.0	-	-	1	17,886.0	-	-	-	-	-	-
3	Зардлын эдийн засгийн ангиллыг зөрчин албан томилолтын зардлаас байрны түрээс, бусад зардалд 11,978.6 мянган төгрөг зарцуулсан.	1	11,978.6	-	-	-	-	1	11,978.6	-	-	-	-
4	Тайлант онд албан томилолтоор ажилласан ажлын тайлан, илтгэх хуудасгүй 7,520.4 мянган төгрөг, тээврийн хэрэгслийн түрээсийн гэрээг дүгнээгүй, жолоочийн тооцооны хуудас хөтлөөгүй 7,253.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.	1	14,773.4	-	-	1	14,773.4	-	-	-	-	-	-
5	Тайлант онд анхан шатны баримтын бүрдэл дутуу, нотлох баримтгүйгээр 9,500.00 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна.	1	9,500.0	-	-	1	9,500.0	-	-	-	-	-	-
6	Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг /элэгдэл тооцох/ Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгаагүй, мөн 2019, 2023, 2024 онд ашиглалтад авсан 765,869.0 мянган төгрөгийн 309 ширхэг үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг 0-1 жил ашиглахаар бүртгэсэн байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
7	Бараа материалын ангилал, бүртгэлтэй холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд: • Бэлэн бүтээгдэхүүний тодорхойлолт, шинж чанарыг агуулаагүй 25 нэр төрлийн 11,960.6	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-

Боловсролын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд
хийсэн аудитын тайлан

	<p>мянган төгрөгийн 2972 ширхэг бараа материалыг тус ангилалд тайлагнасан;</p> <ul style="list-style-type: none"> • Аж ахуйн материал, бусад хангамжийн материалын дансанд ижил төрлийн материалуудыг бүртгэсэн; • Бараа материалын тайланд Үндсэн хөрөнгийн шинж чанар бүхий 125,525.0 мянган төгрөгийн 20 нэр төрлийн 46 ширхэг хөрөнгийг бүртгэсэн; <p>Өмнөх онд ажлаасаа гарсан нярвын нэр дээр 22,877.7 мянган төгрөгийн 64 нэр төрлийн 4,508 ширхэг бараа материалын үлдэгдлийг тайлагнасан байна.</p>												
8	Тайлант онд 458.2 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	458.2	-	-	1	458.2	-	-	-	-	-	-
9	Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн А/132, 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/242 дугаар тушаалаар тус тус Эд хөрөнгийн тооллого хийхээр тооллогын комиссыг томилж, тооллого хийгдсэн боловч тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, тайлагнаагүй байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
	Дүн	9	69,598.5	-	-	6	57,616.9	3	11,978.6	-	-	-	-

Боловсролын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд
хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил													
1	Хугацаа хоцроож оруулсан тайлан, мэдээ 17 байна. Боловсролын яам нь шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 36 харилцагчийн 612,435.8 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний худалдан авалт, 13 удаагийн 303,997.1 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ, аудитын мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан зэрэг нийтэд байршуулбал зохих мэдээллийг байршуулаагүй, 17 тайлан мэдээг хугацаа хоцроож, өмнөх оны аудитаар өгсөн шийдвэр бүрэн хэрэгжээгүй, ижил төрлийн зөрчил давтан гаргасан байна.	1	916,433.7	-	-	-	-	-	-	-	1	916,433.7	1
Дүн		1	916,433.7	-	-	-	-	-	-	-	1	916,433.7	1
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил													
1	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 65,865.9 мянган төгрөгийн 6 төсөл, арга хэмжээг тусгаагүй байна.	1	65,865.9	-	-	-	-	1	65,865.9	-	-	-	-
2	Тайлант онд хэрэгжүүлсэн зарим төсөл арга хэмжээ нь ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, бараа, ажил, үйлчилгээ хүлээн авсан комиссын акт, гэрээ дүгнэсэн актгүй, анхан шатны баримтаар нотлогдохгүй байна. Мөн ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг нарийвчлан боловсруулахгүйгээр ерөнхий байдлаар боловсруулсан, гэрээ дүгнэсэн актад гэрээнд заасан шалгуурууд болон актаар хүлээн авсан бараа, ажил, үйлчилгээний хугацаа, нэр төрлийн талаар нарийвчлан тодорхой тусгахгүй байна.	1	19,391.4	-	-	1	19,391.4	-	-	-	-	-	-
3	Төрийн сангийн программын шинэчлэлттэй холбоотойгоор цахим архив бүрдүүлэх бодлого	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-

Боловсролын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд
хийсэн аудитын тайлан

баримтлан ажиллаж байна. Гэвч санхүүгийн баримтуудад цахим болон цаасан архив үүсгэх, хадгалах, хамгаалахад баримтлах дотоод журам, дүрмийг тодорхой болгож, мөрдөх шаардлага үүссэн байна. Тухайлбал: 1.Цалингийн тооцооны болон цалин олгох хүснэгтийг батлагдсан маягтаар хийж дарга, нягтлан бодогч нар баталгаажуулаагүй, холбогдох тушаал шийдвэр, цагийн бүртгэл зэргийг нэгтгэж архивын нэгж үүсгээгүй; 2.Дараа тайлангийн тооцоо, холбогдох баримт материалыг нэгтгэж архивын нэгж үүсгээгүй; 3.Гэрээгээр гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төсөв, гүйцэтгэл, хяналтын тайлан, актууд зэргийг нэгтгэн архивын нэгж үүсгээгүй байна.											
Дүн	3	85,257.3	-	-	1	19,391.4	2	65,865.9	-	-	-
Нийт дүн	4	1001,691.0			1	19,391.4	2	65,865.9	1	916,433.7	1



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 33/А0171261

Улаанбаатар хот

САГ - 2026/46/НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Боловсролын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд эд хөрөнгийн тооллогын комиссыг Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн А/132, 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/242 дугаар тушаалаар томилж, тооллого хийсэн боловч тооллогын бүртгэлийг баталгаажуулж, тооцоог бодоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана.", 2-т "түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-ээс/", 72 дугаар зүйлийн 4-т "Тооллогын комисс дараах үүрэгтэй: 4/комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.2 "хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй"-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тооллогын бүртгэлийг баталгаажуулж, тооцоог бодоогүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Х.Батжаргал/, ахлах нягтлан бодогч /Б.Мэнд-Амар/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

С.НАЦАГДОРЖ

Г.ОЮУНТӨГӨЛДӨР

Д.БАТЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-204230

9025001-111

Z:\Alban Shaardlaga\2026\0124 SAG-3.Docx

1526180091



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 34/А0171261

Улаанбаатар хот

САГ - 2026/46/НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Боловсролын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд хэрэгжүүлсэн зарим төсөл арга хэмжээ нь ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, бараа, ажил, үйлчилгээ хүлээн авсан комиссын акт, гэрээ дүгнэсэн актгүй, анхан шатны баримтаар нотлогдохгүй байна. Мөн ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг нарийвчлан боловсруулахгүйгээр ерөнхий байдлаар боловсруулсан, гэрээ дүгнэсэн актад гэрээнд заасан шалгуурууд болон актаар хүлээн авсан бараа, ажил, үйлчилгээний хугацаа, нэр төрлийн талаар нарийвчлан тодорхой тусгахгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Захиалагч техникийн тодорхойлолтод бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгана", 12.2-т "Техникийн тодорхойлолтод бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд хэрэглэх түүхий эд, материал болон ажлын хүрээнд нийлүүлэх барааны шалгуур үзүүлэлтийг тодорхойлно", Иргэний хуулийн 195 дугаар зүйлийн 195.2-т "Гэрээ байгуулах саналд гэрээний гол нөхцөл буюу түүнийг тодорхойлох журмыг заасан байна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол"-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Тайлант онд хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээ нь ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, бараа, ажил, үйлчилгээ хүлээн авсан комиссын акт, гэрээ дүгнэсэн актгүй, анхан шатны баримтаар нотлогдохгүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Х.Батжаргал/, ахлах нягтлан бодогч /Б.Мэнд-Амар/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

С.НАЦАГДОРЖ

Г.ОЮУНТӨГӨЛДӨР

Д.БАТЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 35/АД171261

Улаанбаатар хот

САГ - 2026/46/НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Боловсролын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Анхан шатны баримтын бүрдэл дутуу, зориулалт тодорхойгүй 15,002,350.00 /Арван таван сая хоёр мянга гурван зуун тавин/ төгрөгийг зарцуулж, санхүүгийн тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6 "төсвийг зориулалт бусаар зарцуулсан -д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдэл дутуу, зориулалт тодорхойгүй ажил, гүйлгээг бүртгэлд тусгаж байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Х.Батжаргал/, ахлах нягтлан бодогч /Б.Мэнд-Амар/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

С.НАЦАГДОРЖ

Г.ОЮУНТӨГӨЛДӨР

Д.БАТЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага толруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

Z:\Alban Shaardlaga\2026\0124 SAG-3.Docx

1526180081



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 36/A0171261

Улаанбаатар хот

САГ-2026/46/НА - СТА - ТШЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Боловсролын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 36 харилцагчийн 612,435,788.00 /Зургаан зуун арван хоёр сая дөрвөн зуун гучин таван мянга долоон зуун наян найман/ төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний худалдан авалт, 13 удаагийн 303,997,100.73 /Гурван зуун гурван сая есөн зуун ерэн долоон мянга нэг зуун/ төгрөгийн зарлагын гүйлгээ, аудитын мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан зэрэг нийтэд байршуулбал зохих мэдээллийг байршуулаагүй, 17 тайлан мэдээг хугацаа хоцроож, өмнөх оны аудитаар өгсөн шийдвэр бүрэн хэрэгжээгүй, ижил төрлийн зөрчил давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.1. "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3. "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.6-д "худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн", 10 дугаар зүйлийн 10.1-д "Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1-д "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах." гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3. "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг хуулийн хугацаанд, үнэн зөв, иж бүрэн мэдээлээгүй, өмнөх оны аудитаар өгсөн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлээгүй, ижил төрлийн зөрчил давтан гаргаж, албан үүргээ хангалтгүй биелүүлсэн ахлах нягтлан бодогч Б.Мэнд-Амарт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2026 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Х.Батжаргал/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

С.НАЦАГДОРЖ

Г.ОЮУНТӨГӨЛДӨР

Д.БАТЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 37/А0171261

Улаанбаатар хот

САГ - 2026/46/НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Боловсролын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд урсгал засвар болон тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээнд ажил гүйцэтгэх гэрээ байгуулаагүй, гүйцэтгэх ажлын төсөв, тооцоогүй нийт 17,886,000.00 /Арван долоон сая найман зуун наян зургаан мянган/ төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно", 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1 "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Урсгал засварын ажлыг гүйцэтгүүлэхдээ гэрээ байгуулаагүй, ажлын төсөв, тооцоогүй, зарцуулж байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Х.Батжаргал/, ахлах нягтлан бодогч /Б.Мэнд-Амар/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

С.НАЦАГДОРЖ

Г.ОЮУНТӨГӨЛДӨР

Д.БАТЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-24230

9025681411

Z:\Alban Shaardlaga\2026\0124 SAG-3.Docx

1526180085



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 38/A0171261

Улаанбаатар хот

САГ - 2026/46/НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Боловсролын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд анхан шатны баримтын бүрдэл дутуу, нотлох баримтгүйгээр 9,500,000.00 /Есөн сая таван зуун мянган/ төгрөгийн шатахуун зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:", 14.4.1-д "аж ахуйн бүх ажил, гүйлгээ" гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1 "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдэл дутуу, нотлох баримтгүйгээр шатахуун зарцуулж байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Х.Батжаргал/, ахлах нягтлан бодогч /Б.Мэнд-Амар/ нарт даалгав.


АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

С.НАЦАГДОРЖ

Г.ОЮУНТӨГӨЛДӨР

Д.БАТЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 39/А0171261

Улаанбаатар хот

САГ - 2026/46/НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Боловсролын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 458,232.25 /Дөрвөн зуун тавин найман мянга хоёр зуун гучин хоёр/ төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.7 “Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй”-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тайлант онд үүссэн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Х.Батжаргал/, ахлах нягтлан бодогч /Б.Мэнд-Амар/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

С.НАЦАГДОРЖ

Г.ОЮУНТӨГӨЛДӨР

Д.БАТЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 40/АД171261

Улаанбаатар хот

САГ-2026/46/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Боловсролын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд албан томилолтоор ажилласан ажлын тайлан, илтгэх хуудасгүй 7,520,350.00 /Долоон сая таван зуун хорин мянга гурван зуун тавин/ төгрөг, тээврийн хэрэгслийн түрээсийн гэрээг дүгнээгүй, жолоочийн тооцооны хуудас хөтлөөгүй 7,253,000.00 /Долоон сая хоёр зуун тавин гурван мянган/ төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар 2-т "Мөнгөн урьдчилгааны тайлан "Мөнгөн урьдчилгааны тайлан нь гадаад, дотоод албан томилолт, хангамжийн урьдчилгаа гэх мэт бүх төрлийн мөнгөн урьдчилгааны гүйцэтгэлийг тайлагнах үндсэн баримт юм. Урьдчилгаа авагчийн гаргасан гүйцэтгэл ба олгосон урьдчилгаа, холбогдох анхан шатны баримттай харьцуулан нягтлан бодогч урьдчилгаа тайланг хянах ба илүү/дутуу зарцуулалтыг урьдчилгааны зориулалт тус бүрээр гаргана", Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/93 дугаар тушаалаар баталсан "Журам шинэчлэн батлах тухай" журмын 3.6.6-д "Албан хаагч нь гадаадад томилолтоор ажилласан эцсийн хугацаанаас хойш ажлын 5 өдөрт багтаан томилолтын тайлан, зардлын гүйцэтгэлийн баримтыг Гадаад харилцаа хамтын ажиллагааны нэгжид, хөдөө орон нутагт ажилласан бол Төрийн захиргааны удирдлагын нэгж болон Санхүү хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжид тус тус хүлээлгэн өгнө" гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10 "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-26 230

Z:\Alban Shaardlaga\2026\0124 SAG-3.Docx

1526180087

1. Албан томилолтын зардлын ажлын тайлан, илтгэх хуудасгүй, тээврийн хэрэгслийн түрээсийн гэрээг дүгнээгүй, жолоочийн тооцооны хуудас хөтөлдөггүй зэрэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Х.Батжаргал/, ахлах нягтлан бодогч /Б.Мэнд-Амар/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

С.НАЦАГДОРЖ

Г.ОЮУНТӨГӨЛДӨР

Д.БАТЧИМЭГ